

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж:

1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

1. Аль нь хуучин чулуун зэвсгийн дунд үе вэ? /1 оноо/
 A. 800 000-100 000 жилийн үед B. 100 000-40 000 жилийн үед C. 40 000-15 000 жилийн үед
 D. 15 000-8000 жилийн үед E. 8000-3000 жилийн үед
2. Палеолитын үеийг Монголын түүх судлалд монголоор юу гэж нэрлэж заншсан бэ? /1 оноо/
 A. Хуучин чулуун зэвсэг B. Дунд чулуун зэвсэг C. Шинэ чулуун зэвсэг
 D. Хүрэл зэвсэг E. Төмөр зэвсэг
3. Эхийн эрхт овгийн үндсэн шинжүүдийг дурьдахдаа илүүц зүйл өгүүлсэн байна уу? /1 оноо/
 A. Цусан төрлийн холбоо бүхий хүмүүсийн бүлэг
 B. Ясан төрлийн холбоо бүхий бүлэг хүмүүсийн нэгдэл
 C. Овгийн ахлагч нь эх хүн байна. D. Хүүхдүүд нь эхээрээ овоглоно.
 E. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.
4. Эртний хүмүүсийн хэрэглэж байсан хүрэл зэвсэг ямар найрлагатай байдаг вэ? /1 оноо/
 A. Хүрэл эдлэлд зэс 50%, цагаан тугалга 50% ордог
 B. Хүрэл эдлэлд зэс 60%, цагаан тугалга 40% ордог
 C. Хүрэл эдлэлд зэс 90%, цагаан тугалга 10% ордог
 D. Хүрэл эдлэлд зэс 70%, цагаан тугалга 30% ордог
 E. Хүрэл эдлэлд зэс 10%, цагаан тугалга 90% ордог
5. Нийгмийн хөдөлмөрийн хуваарийн үүслийг тодорхойлно уу? /1 оноо/
 A. Багаж зэвсэг хийх, нум сум агсаж ан агнах зэрэг ажлыг эрэгтэйчүүд голлон хийдэг болсон
 B. Гал голомтоо сахиж, үр хүүхдээ өсгөх ажлыг эмэгтэйчүүд голлон хийдэг болсон
 C. Хүмүүсийн нэг хэсэг нь мал аж ахуй, нөгөө хэсэг нь ан агнуур эрхлэн амьдрах болсон
 D. А ба В хариулт хамаарна.
 E. В ба С хариулт хамаарна.
6. Дараах баримтыг уншаад тохирох дүгнэлтийг хийнэ үү? /2 оноо/
“Жужаны хаан буддын шашны судар, их бага ухааныг тайлж эзэмшсэн лам Дармаприяг төрийн багшаар өргөмжлөн 3000 өрх соёрхон олгож байжээ”.
 A. Жужанд бурхны шашин дэлгэрч байсныг гэрчилнэ.
 B. Бурхны шашинг Жужаны хаад төрийн шашны хэмжээнд өргөмжилжээ.
 C. Жужаны язгууртнууд улсын багш нар харьяат иргэнтэй болжээ.
 D. Дээрх хариултууд хамаарна.
 E. Зөвхөн А ба С хариулт хамаарна.
7. Түрэгийн мэргэн сайд Тоньюкукийн гэрэлт хөшөө хаана байдаг вэ? /1 оноо/
 A. Орхоны хөндий B. Хөшөө цайдам C. Налайхын орчим
 D. Хэрлэнгийн хөдөө арал E. Хархорум орчим
8. 744 онд өөрийгөө Куль Билгэ хаанд өргөмжилж Уйгар улсыг байгуулсан хаан хэн бэ? /1 оноо/
 A. Култегин B. Тоньюкук C. Моюнчур D. Буман E. Пэйло
9. Уйгарын хаант улс задран унах болсон гол шалтгаанд аль нь хамаарахгүй вэ? /2 оноо/
 A. Эрх мэдлийн төлөөх дотоодын тэмцэл B. Киргизүүдийн тусгаар тогтнолын төлөөх тэмцэл
 C. Монгол угсааны аймгуудын тэмцэл D. Хөрш улсуудын довтолгоон
 E. Хан улсын довтолгоон
10. XI-XII зууны үед Найман аймгийн нутаг нь хаагуур байсан бэ? /1 оноо/
 A. Заг Байдраг, Сэлэнгэ Туул, Элсэн говийн хооронд
 B. Орхоны адаг, Сэлэнгийн дунд биеэр
 C. Хөлөн Буйр нуураар төвлөрч байв.
 D. Хэрлэн, Онон, Туул голын сав газраар
 E. Орхон голоос Эрчис мөрөн, Хангайн нуруунаас Алтайн чанад хүрч байв.
11. “Алтан ураг”-ийн үндсэн шинжид хамааралгүй зүйл өгүүлсэн байна уу? /1 оноо/
 A. Хаадыг “Тэнгэрийн хөвгүүд” хэмээн үзнэ. B. Хэрэйдийн ноёлогч хэсгийнхэн хамрагдана.
 C. Алунгоогийн домгоос эхтэй D. Чингис хааны үеэс жинхэнэ ёсоор алтан ураг бий болжээ.
 E. Энд ийм зүйл өгүүлээгүй байна.

12. Эрдэмтэд нийт Монгол аймгуудыг талын ба ойн гэж хуваасан байдаг. Ойн аймгийг тодорхойлох үндсэн шинж юу вэ? /1 оноо/
 А. Мал аж ахуй голлон эрхлэнэ. В. Ан гөрөө голлон эрхлэнэ.
 С. Цаа буга, сарлаг зэрэг онцлог сүрэгтэй. D. А ба В хариулт зөв. E. В ба С хариулт зөв.
13. Боржигон овгийн эх үндсийг хэн тавьсан бэ? /1 оноо/
 А. Бугу Хатаги В. Бугути Салжи С. Бодончар D. Бэгтэр E. Бэлгүдэй
14. Рашид Ад Дины “Сударын чуулган”-д “Тэр хоёр хүмүүн/нохос, хиан/–ий үр язгуурын дотор Бүртэ чино гэдэг хүндтэй нэгэн буй. Тэр бол хэд хэдэн аймгийн ахмад мөн. Гоо марал нэртэй аваал эмээс нь гарсан нэгэн хөвгүүн олноос онцгой бөгөөд хожим нь хан цолтой байжээ. Энэ хөвгүүнийх нь нэр Батцагаан гэдэг” хэмээсэн нэгэн баримт байна. Энэ баримтад сурагчид өөр өөрийн гаргалгаа хийсэн байна. Хэнийх нь зөв вэ? /2 оноо/
 А. Сурагч Бат “Монгол аймгийн язгууртнууд “хан” цол хэрэглэж байсан байна” гэжээ.
 В. Сурагч Амар “Бүртэ чино-ийн эхнэр нь Гоо марал” гэсэн
 С. Сурагч Дорж “Батцагаан бол Бүртэ чино-ийн удам угсаа” гэсэн
 D. Бат Амар нарын хийсэн гаргалгаа зөв.
 E. Энэ гурван сурагчийн хийсэн гаргалгаа гурвуулаа зөв.
15. Дор өгүүлсэн зүйлээс Их Монгол улс байгуулагдах түүхэн боломжийг ялгаж нэрлэнэ үү? /2 оноо/
 А. Аймаг хоорондын зөрчил тэмцлийг намжаах
 В. Улс төрийн бүлэглэлүүдийн хоорондын тэмцлийг зохицуулах
 С. Зүрчидийн Алтан улсын эсрэг хүчээ нэгтгэх
 D. Хамаг Монголын ханлигийн нэгдэл сэргэсэн.
 E. Аймаг ханлигуудын хооронд аж ахуйн харилцаа холбоо тогтоох
16. Их Монгол улсын нутаг дэвсгэрийг баруун, зүүн, төвийн гэсэн гурван их түмэнд хуваасан байжээ. Төвийн түмнийг хэн захирч байсан бэ? /1 оноо/
 А. Мухулай В. Шихихутаг С. Боорчи D. Зэлмэ E. Наяа
17. XIII зууны эхэн үед Монголын баруун талд ямар улс оршин байв? /1 оноо/
 А. Сүн улс В. Алтан улс С. Си-Ся буюу Тангуд улс D. Хорезми E. Хятан
18. 1206 онд байгуулагдсан Их Монгол улсын хилийн өмнө тал нь хаагуур хиллэж байсан бэ? /1 оноо/
 А. Байгаль нуур В. Түмэн газрын Цагаан хэрэм С. Хянганы нуруу
 D. Алтайн нурууны чанад E. Хөвсгөлийн уулс
19. Чингис хаан төрийн гарамгай зүтгэлтэн гэсэн нэр алдрыг олоход ажил амьдралдаа ямар зүйлийг гол мөрдлөг болгож байсан бэ? /1 оноо/
 А. Төрөө эрхэмлэн дээдлэх үзлийг Монгол хүн бүрийн оюун сэтгэлд гүн бат суулгаж өгсөн.
 В. Төрийн түшээг сонгохдоо тухайн хүний ухаан, ур чадвар, байгуулсан гавьяа, үнэнч байдлыг онцолдог.
 С. Хуулийг сахин биелүүлэх D. А, В, С хариулт хамаарна..
 E. А ба С хамаарна.
20. Монголын зарим хаадын хаан сууж байсан хугацааг зөв оноон тохируулна уу? /2 оноо/
 А. Өгэдэй 1. 1251-1259 он
 В. Гүюг 2. 1260-1294 он
 С. Мөнх 3. 1228-1241 он
 D. Хубилай 4. 1246-1248 он
 А. a1, b2, c3, d4 В. a2, b1, c4, d3 С. a3, b4, c2, d1 D. a3, b4, c1, d2 E. a4, b3, c1, d2
21. Монголын XIII-XIV зууны үеийн соёлд хамаарах зүйлүүдийг дор өгөгдсөн өгөгдлөөс цэгийн оронд холбогдох утгаар нь нөхөн бичнэ үү? /2 оноо/
 Одоогоор олдоод байгаа монгол бичгийн хамгийн эртний анхны дурсгал нь 1.бөгөөд, Их Монгол улсын үед 2.....бичгийг төрийн албан ёсны бичиг болгожээ. Тэрчлэн 1269 онд Хубилай хааны зарлигаар 3. үсгийг зохиож, гүрний хэмжээнд төрийн албанд хэрэглэж байжээ.
 Нөхөх үгс :
 а. Мөнх хааны гэрэлт хөшөө
 b. Чингисийн чулууны бичиг
 c. Монгол бичиг
 d. Тод үсэг
 e. Дөрвөлжин үсэг
 А. 1e, 2b, 3d В. 1a, 2c, 3d С. 1c, 2e, 3d D. 1b, 2c, 3e E. 1b, 2d, 3c

22. Монголын улс төрийн бутралын үе түүхийн аль цаг үеийг хамаардаг вэ? /1 оноо/
 A. НТӨ 209-НТ XIII зуун B. XIII-XIV зуун C. XIV зууны дунд үеэс XVII зууны эхэн үе
 D. XVII-XIX зуун E. 1911-1919 он
23. Улс төрийн бутралын үеийн баруун Монголын Ойрад түмэнд аль нь хамаарч байсан вэ? /1 оноо/
 A. Ордос B. Цахар C. Цорос D. Урианхай E. Юншээбү
24. 1639 онд Ширээ цагаан нуурт Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазарыг Халх Монголын шарын шашны тэргүүнээр өргөмжилжээ. Энэ үйл явдал хэддүгээр жаранд болсон бэ? /1 оноо/
 A. 10 дугаар жаран B. 11 дүгээр жаран C. 12 дугаар жаран
 D. 13 дугаар жаран E. 14 дүгээр жаран
25. Сурвалж бичгүүдэд Энэтхэг, Төвөд, Монголыг номын барилдлагат гурван орон хэмээн тэмдэглэсэн байдаг нь нэгэн шашнаар шүтэн барилдсанаас тийнхүү нэрийджээ. Зарим судлаачид дээрх томъёоллыг дараах байдлаар нэрлэсэн байдаг бөгөөд тэдгээрийг зөв харгалзуулна уу? /2 оноо/
 A. Гүүний сүүгээр цэнгэгчийн орон 1. Энэтхэг
 B. Хутагтын орон 2. Төвөд
 C. Цастын орон 3. Монгол
 A. A1, B2, C3 B. A2, B1, C3 C. A3, B2, C1 D. A3, B1, C2 E. A2, B3, C1
26. Дараах өгөгдлүүдэд буруу зүйл өгүүлсэн байна уу? /2 оноо/
 A. 1686 онд Заг Байдрагийн Хүрэн бэлчирт Манжийн хааны оролцоотойгоор ноёдын чуулган болсон.
 B. 1688 онд Ар элстэй гэдэг газар Халхын хувь заяаны асуудлыг шийдвэрлэсэн чуулган болов.
 C. 1691 онд Ар Халхад Халх Ойрадын ноёдын чуулган болж “Халх-Ойрадын Их цааз”-ыг батлан гаргав.
 D. 1755-1758 онд Манжийг эсэргүүцсэн Монголчуудын тусгаар тогтнолын төлөө тэмцэл, зэвсэгт бослого гарав.
 E. Тийм зүйл өгүүлээгүй байна.
27. XIX зууны эхээр Төвөд хэлээр “Гайхамшигт нүдний чимэг” зохиол бичиж, 582 төрлийн эмийн түүхий эдийг тодорхойлсон эрдэмтэн хэн бэ? /1 оноо/
 A. Зая бандида Намхайжамц B. Ламын гэгээн Лувсанданзан
 C. Сүмбэ хамба Ишбалжир D. Халхын зая бандида Лувсанпэрэнлэй
 E. Найманы Жамбалдорж
28. Халх Монгол Манжийн эрхшээлд ороход ямар хүчин зүйл нөлөөлсөн бэ? /2 оноо/
 A. Цогт хунтайж, Лигдэн хааны хоорондын зөрчил тэмцэл
 B. Халх, Зүүн гар хоёр хамтран Манжийн эсрэг тэмцсэн авч хүчин мөхөсдөн
 C. Халхын дотоодын зөрчил тэмцэл болон Манж Чин улсын Монголчуудыг хагалан бутаргах бодлого
 D. Манж нар Зүүн гарын хант улсын хүчийг ашигласан
 E. Энх-Амгалан хаан Галдан бошигт нар хүчин хавсарч Халхын эсрэг тэмцсэн
29. 1725 онд Сайн ноён хан аймгийг нэмж байгуулснаар Халх 4 аймагтай болжээ. Энэ үйл явдал хэддүгээр зууны хэддүгээр хагаст болсон бэ? /1 оноо/
 A: XVI зууны I хагас B. XVI зууны II хагас C. XVII зууны I хагас
 D. XVII зууны II хагас E. XVIII зууны I хагас
30. Дор дурьдсан шинжүүдийн аль нь шавь нар гэсэн нийгмийн давхрааг тодорхойлж байна вэ? /1 оноо/
 A. Манжийн захиргааны хэрэгт хүчин зүтгэдэг монголын нийгмийн давхрааны дээд хэсэг
 B. Манжийн төрийн олон зүйлийн хүнд хүчир албанд зүтгэдэг цэрэг эр
 C. Аймаг, хошууныхаа ноёд язгууртнуудын мэдэлд захирагддаг харьяат албат
 D. Хутагт хувилгаад, сүм хийдийн мэдэлд захирагдагсад
 E. Манжийн харуулын алба хаадаг хүмүүс
31. Галдан бошогт хааны түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, үйл ажиллагааны тухай дурьдахдаа хамааралгүй зүйл өгүүлсэн байна уу? /2 оноо/
 A. Галдан бошогтын зорилго нь “Их цааз”-ын үзэл санааг хэрэгжүүлэх
 B. 1676 онд Ойрад Монголчуудыг нэгтгэж нэгдмэл хүчирхэг болгов.
 C. Манжийн түрэмгийллийг эсэргүүцэх
 D. Галдан бошогт хүчин мөхөсдөж байсан ч эцсийн мөч хүртэл тусгаар тогтнолоо хамгаалж, Манжийн эсрэг тэмцэж байв.
 E. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.
32. Манжийг эсэргүүцсэн 1755-1758 оны зэвсэгт тэмцлийг хэн, хэн удирдсан бэ? /1 оноо/
 A. Амарсанаа, Чингүнжав B. Амарсанаа, Цэнгүнжав
 C. Чингүнжав, Галдан D. Рэнчиндорж, Цэнгүнжав E. Сэвдэнбалжир, Банди

33. Манж Чин улсын үеийн Өвөр Монголын нутаг

Чуулган	хошуу
Жирмийн чуулган	10
Зостын чуулган	5
Зуун-Уд	10
Улаанцав	7
Их зуу	6

Энэ баримтанд хийсэн доорх дүгнэлтүүдээс аль нь хамаарах вэ? /2 оноо/

- A. Өвөр Монголын газар нутаг 5 чуулганд хуваагдаж байжээ.
 B. Хамгийн олон хошуутай нь Жирэм чуулган, Зуун-удын чуулган байв.
 C. Энэ баримтанд Өвөр Монголын 48 хошууны тухай дурьджээ.
 D. А ба В зөв
 E. В ба С зөв

34. 1880 онд ард Онолтоор удирдуулсан бослого хаана гарсан бэ? /1 оноо/

- A. Сайн ноён хан аймагт B. Түшээт хан аймагт C. Сэцэн хан аймагт
 D. Засагт хан аймагт E. Ховдын хязгаарт

35. Манжийн төрийн шинэ засгийн бодлогын хүрээнд улс төрийн салбарт авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээнүүдийг ялган нэрлэнэ үү? /2 оноо/

- Манжийн төр хятадын худалдаа мөнгө хүүлэгч пүүсүүдийг дэмжих
 - "Монгол үгийн бодрол" сонинг Хятад Монголоор хэвлэн тараав.
 - ГМТЗЯЯ-ны бүтцэд өөрчлөлт оруулан, "Байцаах товчоо" "Найруулах товчоо"-г байгуулав.
 - Уурхай байгуулж ашигт малтмал олборлох, байгалийн баялагыг ашиглах, банк байгуулах зэрэг санал дэвшүүлэн хэрэгжүүлж эхлэв.
 - 1905 онд Их Хүрээнд Цагдан цээрлүүлэх яамыг байгуулсан.
 - Зохиомол өрийн данс нээж, өрийг ихэсгэв.
 - Манж-Хятад хэлний сургуулиуд байгуулав.
 - Монголын цэрэг, харуулын байршил, тоог тодорхойлон гаргасан.
 - Монголчуудыг "мэдлэг ухаан бас бурангуй" гэж бичиж байсан.
- A. 1, 3, 5 B. 2, 7, 9 C. 3, 5, 8 D. 1, 4, 6 E. 3, 4, 5

36. Дор дурьдсан оны цол, цаглавраас Монголчуудын 1911 оноос эхлэн хэрэглэснийг нь нэрлэнэ үү? /1 оноо/

- A. Олноо өргөгдсний B. Монгол улсын C. Хэвт ёсны
 D. Найралт төвийн E. XVII жарны

37. Сурагч Болдын аав Түвдэн одоогийн Төв аймгийн нутагт төржээ. Энэ нь уламжлалт засаг захиргааны хуваариар аль аймаг вэ? /1 оноо/

- A. Засагт хан аймаг B. Түшээт хан аймаг C. Сайн ноён аймаг
 D. Сэцэн хан аймаг E. Дөрвөд Далай ханы аймаг

38. Олноо өргөгдсөн Монгол улсын үеийн Богд хааны эрх хэмжээг дурьдахдаа илүүц зүйл өгүүлсэн байна уу? /2 оноо/

- A. Улсын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх B. Дээд албан тушаалтныг томилох, огцруулах
 C. Гадаад улстай байгуулсан гэрээг батлах D. Улсын дээд хурлыг удирдана.
 E. Энд тийм зүйл дурьдаагүй байна.

39. Дорхи газрын зурагт Сэцэн хан аймгийг хэдийн тоогоор дугаарласан байна вэ? Сонгоно уу? /1 оноо/



- A. 1
 B. 2
 C. 3
 D. 4
 E. 5

40. 1911-1919 онд Монгол улсын соёлын салбарт хийгдсэн шинэтгэлийн учир холбогдол нь юунд байна вэ? /2 оноо/

- A. Монгол орон гадаад ертөнцөөс тусгаарлагдсан байдлаасаа гарч, бусад улс орнуудадтай харилцах болсноор дэлхийн иргэншилд татагдан орсоны үр дүн
- B. Манжийн эрхшээлийн уршгаар бий болсон ахуйн болон сэтгэлгээний хоцрогдлоос ангижрах эхлэлийг тавьсан
- C. Хөгжилтэй орнуудын үлгэр загвараар улс орноо төвхнүүлэн хөгжүүлэх эрмэлзлэлийг бий болгосон.
- D. Дээрх бүгд
- E. А хариулт хамаарна.

41. Доорх төрийн сүлд аль үед хүчин төгөлдөр байсан бэ? /1 оноо/



- A. 1911-1919 оны үед
- B. 1919-1940 оны үед
- C. 1940-1960 оны үед
- D. 1960-1992 оны үед
- E. 1992 оноос

42. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу. /1 оноо/

1921.VII.10-нд Ардын засгийн газрын Дотоод яамны тэргүүн сайдаар-ыг томилжээ.

- A. Да лам Пунцагдорж
- B. Д.Сүхбаатар
- C. Д.Бодоо
- D. С.Данзан
- E. Н.Магсаржав

43. Монголын 1921 оны хувьсгалын удирдагчдын нэг С.Данзангийн үйл ажиллагаа түүхэнд гүйцэтгэсэн үүргийн талаар илүүц зүйл дор өгүүлсэн байна уу? /2 оноо/

- A. 1921 оноос АЗГ-ын Ерөнхий сайдын жинхэнэ орлогч, Сангийн яамны сайдаар ажиллаж байсан.
- B. 1921 оны Монгол-Оросын хэлэлцээрт Монголын төлөөлөгчдийг тэргүүлж оролцсон
- C. Консулын дэнжийн бүлгэмийг үндэслэгчдийн нэг.
- D. Монгол улсын/1911-1919/оны үед Сангийн яаманд түрээсийн түшмэл байсан.
- E. Энд ийм зүйл өгүүлээгүй байна.

44. Дор өгүүлсэн зүйлээс аль нь Д.Сүхбаатарын үзэл бодол вэ? /2 оноо/

- A. “Хэмжээт эрхт хаант засаг бол хуучнаас шинэ байгуулалд шилжих зайлшгүй байх ёстой засаглалын хэлбэр тул тухайн цаг үед нэг хэсэгтээ тохиромжтой.”
- B. “... Бурхны шашнаа хүндэтгэж ард түмнийг амгалан туйл дор хүргүүлэн тэгш журамт баян хүчирхэг улс болохыг гол болгосон хэрэг болой.”
- C. “Юун хэмээвээс ертөнцийн хүн төрөлхтөн бүгдээр найрамдах буюу зөвлөлдөх мэтсийн олон зэрэг дэс байр байх бөгөөд үлгэрлэвээс авирах гишгүүрт нэгээс үүсгэн дэвших ба усанд гүехнээс гүнд орохоор утга адил буй”
- D. “МАН-ын эцсийн зорилт нь эв хамтын ёс мөн бөгөөд нам капитал хөрөнгөтний хөгжлийн шатыг алсгах зорилгод хүрэхээр урагшаа давшин явж байна.”
- E. Аль нь ч биш.

45. 1921-1924 онуудад гадаад бодлогын салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг нэрлэнэ үү? /2 оноо/

1. 1921 оны 11 дүгээр сард Судар бичгийн хүрээлэнг байгуулав.
2. 1921 оны 11 дүгээр сард Монгол-ЗОУ-ын хооронд гэрээ байгуулагдав.
3. 1923 онд Монгол-Зөвлөлтийн худалдаа, эдийн засгийн гэрээ байгуулагдав.
4. 1921 оны 11 дүгээр сард бага сургууль байгуулагдав.
5. Байнгын засгийн газар байгуулагдав.
6. “Уриа”, “Ардын эрх”, “Ардын цэрэг”, “Ургинская газета”, “Манай үнэн” зэрэг сонин хэвлэгдэн гарав.
7. Ховд, Зүүн Хараад төрийн өмчийн тариалангийн газар-сангийн аж ахуй байгуулав.
8. 1921 оны 10 дугаар сард тунхаг гаргаж хэмжээт хаант Монгол улс байгуулагдснаа дэлхийн олон улсад зарлан мэдэгдэв.
9. Хувийн өмчинд байсан жижиг үйлдвэрүүдийг улсын болгов.

- A. 3, 5, 7
- B. 1, 2, 3
- C. 2, 4, 6
- D. 2, 3, 8
- E. 7, 8, 9

46. Коминтерн, ОК/б/намын Монголд нийгэм журмыг шууд байгуулах чиг бодлого баримтлан хэрэгжүүлж байсан зүүнтнүүд хэмээн нэрлэгдэж байсан улс төрийн хүчнүүд хэдий үед Монголын засаг төрийн эрхийг барьж байв? /1 оноо/

- A. 1921-1924 он
- B. 1924-1928 он
- C. 1929-1932 он
- D. 1932-1934 он
- E. Энд тухайн он цагийг заагаагүй байна

47. “Феодал” агчдын хөрөнгийг хураах кампанит ажлын үед хөрөнгөө хураалгасан өрхөд малын үнээр тооцвол 4,7 сая орчим төгрөгийн хөрөнгө үлдээжээ. Нийт хичнээн өрхийн хөрөнгө хураасан бэ? /2 оноо/
 А. 1000 орчим өрхийн В. 1560 орчим өрхийн С. 2000 орчим өрхийн
 D. 2500 орчим өрхийн Е. 3000 орчим өрхийн
48. Дор дурьдсан үйл явдлуудаас Шинэ эргэлтийн бодлогын үед хамаарахыг нэрлэнэ үү? /2 оноо/
 1. Улсын дээд, доод хурал байгуулагдав.
 2. Монгол, ЗОУ-ын хооронд найрамдлын гэрээ байгуулжээ.
 3. “Феодал” агчдын хөрөнгийг хураав.
 4. “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг” хууль гарчээ.
 5. Хувийн худалдааг хориглохоо больж, худалдаачдад тусламж дэмжлэг үзүүлэв.
 6. Жасын кампни гэж нэрлэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэв.
 7. Богд хаан ба Засгийн газрын хооронд “Тангарагийн гэрээ” байгуулав.
 8. Олноор байгуулсан хамтрал, коммуныг татан буулгав.
 А. 1,4 В. 2,7 С. 3,6 D. 5,8 Е. 4,7
49. Коминтерн Монголын дотоод хэрэгт оролцох болсны үр дагаварт үл хамаарах зүйл өгүүлсэн байна уу? /2 оноо/
 А. Ардчилсан зарчмаас ухарч большевик үзлийг дээдэлсэн засаглалд шилжих
 В. Нийт иргэдийн эрх ашиг, сонирхолыг дээдлэх явдлыг орхиж, зөвхөн ядуу хэсгийг онцлон анхаарах
 С. Хувийн өмч бүхий эдийн засгийн харилцааг хөгжүүлэх
 D. Марксист-ленинист онолыг монголын нийгмийн оюун санааны үндэс болгосон
 Е. Энд тийм зүйл дурьдаагүй байна.
50. Дор дурьдсан үйл явдлуудыг болсон цаг хугацааны дагуу эрэмблэнэ үү? /2 оноо/
 1. Халх голын дайн болов.
 2. Зүүнтнүүд хэмээн нэрлэгдсэн хүмүүс засаг төрийн эрхийг барьж байлаа.
 3. Улсын анхдугаар Их хурал хуралдаж, Үндсэн хууль батлав.
 4. Шинэ эргэлтийн бодлого хэрэгжиж эхлэв.
 А. 3, 1, 2, 4 В. 4, 2, 3, 1 С. 3, 2, 4, 1 D. 1, 2, 3, 4 Е. 2, 4, 1, 3
51. Монголын эх орны дайны жилүүдэд ард түмний хөрөнгөөр үйлдвэрлэсэн ямар нэртэй танкийн цуваа, нисэх онгоцны эскадрилийг улаан армид шилжүүлсэн бэ? /2 оноо/
 А. “Монгол ард” танкийн цуваа, “Хувьсгалт монгол” нисэх онгоцны эскадриль
 В. “Монгол ард” танкийн цуваа, нисэх онгоцны эскадриль
 С. “Монгол ард” нисэх онгоцны эскадриль, “Хувьсгалт монгол” танкийн цуваа
 D. “Хувьсгалт монгол” нисэх онгоцны эскадриль, танкийн цуваа
 Е. “Хувьсгалт монгол” танкийн цуваа
52. Монголын орчин үеийн анхны дууриудын нэгэн болох “Учиртай гурван толгой”-г хэн зохиосон бэ? /1 оноо/
 А. Б.Дамдинсүрэн, Б.Смирнов В. С.Гончигсумлаа, Б.Смирнов
 С. Н.Жанцаноров, Б.Смирнов D. Ж.Чулуун, Б.Смирнов
 Е. Л.Мөрдорж, Б.Смирнов
53. XX зууны монголын урлаг, шинжлэх ухааны зүтгэлтнүүдийн нэрсийг бичсэн тавдугаар мөрийг ямар шалгуурыг баримтлан үүсгэсэн байна вэ? /1 оноо/
 1. Д.Пүрэвдорж, Р.Чойном, С.Удвал, Б.Явуухулан
 2. Ц.Дамдинсүрэн, Б.Ринчин, Ш.Нацагдорж, Б.Ширэндэв
 3. Б.Дамдинсүрэн, Р.Мөрдорж, Д.Лувсаншарав, Г.Бирваа
 4. О.Цэвэгжав, Г.Одон, Н.Цүлтэм, Л.Гаваа
 5. Ж.Жигжид, Б.Сумхүү, Ж.Бунтар, Г.Жигжидсүрэн
 А. Кино урлагийн салбарын төлөөлөл В. Монголын уран зургийн салбарын төлөөлөгчид
 С. Монголын зохиолчдын төлөөлөл D. Монголын хөгжмийн зохиолчдын төлөөлөл
 Е. Монголын шинжлэх ухааны эрдэмтдийн төлөөлөл
54. Дараах өгөгдлүүдэд буруу зүйл өгүүлсэн байна уу? /2 оноо/
 А. 1991 оноос манай улс ОУВС, Дэлхийн банкны гишүүн болов.
 В. 1992 онд Монгол улсын Үндсэн хууль батлагдав.
 С. 1996 оноос жил бүрийн 9 дүгээр сарын 10-ны өдрийг хэлмэгсэдийн дурсгалыг хүндэтгэн мөнхжүүлэх өдөр болгон тэмдэглэх болов.
 D. 2005-2006 оны хичээлийн жилээс ЕБС 12 жилийн сургалттай болов.
 Е. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.

55. Өнөөгийн Монгол улсын гадаад бодлогын дөрөв дэх чиглэл юу вэ? /1 оноо/
 А. АНУ, Япон, ХБНГУ зэрэг өндөр хөгжилтэй орнуудтай найрсаг харилцаа тогтоох
 В. Хуучин социалист гэгдэж байсан дорнод Европын орнуудтай харилцаагаа сэргээх
 С. Уламжлалт харилцаатай хоёр их хөрш ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх
 D. Азийн бүс нутагт байр сууриа бататган энэ бүс нутгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох
 E. НҮБ, түүний төрөлжсөн байгууллагуудтай хамтран ажиллах
56. Өөрчлөлт шинэчлэлийн жилүүдэд эдийн засгийн салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг нэрлэнэ үү? /2 оноо/
 1. 2008 оноос иргэнд газар өмчлүүлэх шийдвэр гарч хэрэгжиж байна.
 2. Улс төрийн намуудын тухай хууль батлагдан, олон намын систем тогтов.
 3. “Монголын нууц товчоо, төрийн хан хуур, морин хуур, төрийн дуулал, төрийн сүлдээ албан байгууллага, айл өрхүүдэд хүндэтгэлтэйгээр залах шийдвэр гарч хэрэгжиж байна.
 4. 2009 онд Монгол улсын төрийн тэргүүнээр Ц.Элбэгдорж сонгогдов
 5. Банкны шинэчлэл хийв..
 6. Монгол бичгээ сэргээх, хос бичигтэн болох ажил өрнөж байна.
 А. 1, 2, 3 В. 3, 4, 6 С. 5, 6 D. 1, 5 E. 4, 5

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ, ДАРААЛАЛ СЭРГЭЭХ ДААЛГАВАР

Санамж:

1. Даалгаврыг хариуг зөв тогтоож харгалзуулах, дараалал сэргээх байдлаар гүйцэтгэнэ үү.
2. Зөв хариулт бүр 1 оноотой.

- 2.1 Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүнд нь багтаж байсан улсуудын газар нутгийг тэмдэглэсэн дугаартай нь тохируулна уу? /5 оноо/

- А. Алтан орд улс
- В. Цагаадайн улс
- С. Ил хант улс
- D. Юань гүрэн
- E. Юань гүрний бүрэлдэхүүнд багтаж байсан Монгол



- 2.2 Дараах хаадыг холбогдох үйл ажиллагаатай нь тохируулна уу? /5 оноо/
- | | |
|----------------------|--|
| А. Өгөөдэй хаан | 1.” Үлэмж жаргалангаар хүн амьтныг хангаж байсан” үе |
| В. Хубилай хаан | 2. Эцгийн тайш цолыг залгамжлан хаан суусан. |
| С. Эсэн хаан | 3. Монголын хаадын дотроос анх түрүүн өөрийн үйл ажиллагаандаа дүгнэлттэй хандсан. |
| D. Батмөнх даян хаан | 4. Бүх Хятадыг эзлэн авч мэдэлдээ оруулсан. |
| E. Түмэн засагт хаан | 5. “Гар газар, хөл хөсөр байсан” үе |

- 2.3 Монголын болон Монгол нутаг дээр оршиж байсан эртний улсуудын хаадыг амьдарч байсан он цагийн дарааллаар/эхнийхээс нь эхлэн 1-5 гэж дугаарлана/нь эрэмбэлнэ үү? /5 оноо/
- А. Моюнчур
 - В. Түмэн
 - С. Чаругуй
 - D. Буман
 - E. Таньшихуай

- 2.4 Цэгийн оронд тохирох утгыг нөхөж бичнэ үү? /5 оноо/
 Монгол улсын Их хурал нь А., улсын ерөнхийлөгч нь В., засгийн газар нь С. юм.
 Өөрийн удирдлагын байгууллага нь аймаг сумдад D., баг, хороонд E. байдаг.
1. Иргэдийн төлөөлөгчдийн хурал
 2. Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч
 3. Иргэдийн нийтийн хурал
 4. Төрийн эрх барих дээд байгууллага
 5. Төрийн гүйцэтгэх дээд байгууллага